



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/85

Улаанбаатар хот

Ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 6.3.5, “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ын 3.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга, хот байгуулалтын яамны 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 3/1812, Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 1/1915 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн хавсралтад заасан 6 аж ахуйн нэгж, байгууллагын нийт 221 гадаад ажиллах хүч, мэргэжилтний ажлын байрны төлбөрийг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 50 хувиар хөнгөлсүгэй.

2. Хөнгөлөлтөд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын урьдчилж төлсөн 2022 оны ажлын байрны төлбөрийн зөрүүг дараагийн төлбөрт шилжүүлэн тооцох, буцаан олгох арга хэмжээ авахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /Л.Дашдэмбэрэл/-т даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /С.Дамбий/-т даалгасугай.

САЙД



А.АРИУНЗАЯА

• 151201520

D: 2022 on 04 sar tushaal

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2022 оны 04 дугаар
тушаалын хавсралт



**АЖЛЫН БАЙРНЫ ТӨЛБӨРӨӨС ХӨНГӨЛӨХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА,
ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГАДААДЫН АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТНИЙ ТОО**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Гүйцэтгэх үйл ажиллагаа	Гадаадын ажиллах хүч, мэргэжилтний тоо	Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгосон эрх зүйн баримт бичиг	Асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал
Барилгын салбарт үйл ажиллагаа явуулах					
1	“Тэнүүн цамхаг өргөө” ХХК	Баянзүрх дүүргийн 25 дугаар хороонд “Мандала” хотхоны Б1-Б5 блокны гадна фасад, доторх хана болон дотоод заслын ажил, тус хорооны “Баянзүрх” апартмент хотхоны Б3, Б4, А1, Д3 блокны өрлөг, дотоод засал, стандарт цахилгаан гэрэлтүүлэг хийх	15	“Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” Засгийн газрын 2021 оны 392 дугаар тогтоол	Барилга, хот байгуулалтын яамны 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 3/1812 тоот албан бичиг
2	“Хантайширын Оргил Констракшн” ХХК	Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт баригдах “Ботаник цэнтр” хотхоны барилгын ажил гүйцэтгэх	15	“Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгах тухай” Засгийн газрын 2021 оны 391 дүгээр тогтоол	Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 1/1915 тоот албан бичиг
3	“Хангайнган Эрдэнэ” ХХК	Багахангай дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт ган туйвангийн үйлдвэрлэл явуулах	45	“Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” Засгийн газрын 2021 оны 392 дугаар тогтоол	Барилга, хот байгуулалтын яамны 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 3/1812 тоот албан бичиг
4	“Синвоюань” ХХК	Багахангай дүүргийн 1 дүгээр	36	“Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох,	Барилга, хот байгуулалтын

		хорооны нутаг дэвсгэрт туйвангийн үйлдвэрлэл явуулах ган		ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай Засгийн газрын 2021 оны 392 дугаар тогтоол, “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгах тухай” Засгийн газрын 2021 оны 391 дүгээр тогтоол	яамны 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 3/1812 тоот албан бичиг
5	“Эйч Ди Ти Эм” ХХК	Налайх дүүргийн нутаг дэвсгэрт ган туйвангийн үйлдвэрлэл явуулах	70	“Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” Засгийн газрын 2021 оны 392 дугаар тогтоол	Барилга, хот байгуулалтын яамны 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 3/1812 тоот албан бичиг
6	“Мөнхийн баян гал” ХХК	Төв аймгийн сэргэлэн сумын нутаг дэвсгэрт цементийн үйлдвэрлэл явуулах	40	“Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” Засгийн газрын 2021 оны 392 дугаар тогтоол	Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 1/1915 тоот албан бичиг
НИЙТ			221		